

**“ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2025.12.25

Эрүүл мэндийн газар

№	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Биелэлт	Хувь
1	2	3	4	5
Хоёр. Нийгэм төрийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:				
2.5.	Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр холбогдох ажлыг зохион байгуулах;	Жил бүр	<p>Тайлант хугацаанд эмчилгээ, тусламж үйлчилгээний чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн хэмжээнд сэтгэцийнэрүүл мэндийн тусламж үйлчилгээг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрдэнэт клиник, хувийн хэвшлийн 2 клиник үзүүлж байна. Мэргэжлийн сэтгэцийн 6 эмч ажиллаж байна. - Архидалт, мансуурлын эсрэг ассоциаци Орхон Аймаг Дахь Салбар, Мэргэжлийн сэтгэл зүйчдээс бүрдсэн 9 төрийн бус байгууллагууд тогтмол ажиллаж байгаа ба өмнөх оны мөн үеэс 33,3%-иар нэмэгдсэн байна. - БОЭТ-ийн Сэтгэц-наркологиын тасагт 579 хүн хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс: F10 бүлэг буюу архины хордлого оношоор 177, Сэтгэцийн эмгэгийн бусад оношоор 402 хэвтэн эмчлүүлэгчид хэвтэн эмчлүүлсэн. Тасаг нь Хөдөлмөр засал, ном, хөгжим, арт терапи зэрэг заслын эмчилгээ хийж ажилладаг. Сэтгэц наркологиын “Оюу” эмнэлэгт нийт 441 хүн хэвтэн эмчлүүлсэнээс 257 хүн нь архины хордлого тайлах эмчилгээ хийлгэсэн ба хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Эрдэнэт клиникийн сэтгэцийн кабинетаар Архины хамаарлын чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөөнд 214 хүн хамрагдсан байна. - "Эрдэнэт" сувилал, "Монос фарм трейд", "Нью верамед" ХХК-тай хамтран Эрдэнэт үйлдвэрийн 1100 ажилтанд хорт зуршлаас татгалзах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, 1732ш гарын авлага тарааж ажилласан. <p>Сургалт, нөлөөллийн чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - 28 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 5 төрлийн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж 7387 хүн хамрагдсан. - Аддиктологийн төв, Сэтгэц – нийгмийн сэргээн засах төв, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн хөгжлийн хороотой хамтран “Архины хамааралтай хүнд үзүүлэх сэтгэц–нийгмийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох төрийн байгууллагуудын 44 албан хаагчдыг хамруулсан. 	100

			- Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нийгмийн хөгжлийн хорооны 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/12 дугаартай албан бичиг, Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/292 дугаар захирамж, удирдамжийн дагуу архины хэрэглээний эмгэгтэй хүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэтгэц-нийгмийн сэргээн засах төв”, “Аддиктологийн төв”-ийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, улмаар орон нутагт бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх төв байгуулах, донтох эмгэгийн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд салбар дундын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудын 10 хүний бүрэлдэхүүнтэй туршлага судалсан. Мөн орон нутагт нутагшуулах зорилгоор санал оруулан ажилласан байна.	
Гурав. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд				
3.1.	Нийгмийн эрүүл мэндийн байдал, өргөн тархалттай, шинэ болон сэргэж байгаа гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;	Тухай бүр, жил бүр	Томуу, томуу төст өвчний бэлэн байдлыг хангах чиглэлээр аймгийн онцгой комиссын шийдвэрээр батлагдсан 131 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2000 ширхэг түргэвчилсэн оношлуур, 7 төрлийн багаж тоног төхөөрөмж, Н95 амны хаалт 1000ш худалдан авч, салбаруудад хуваарилсан. Орон нутгийн 2025 оны төсөвт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих, томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор 55 сая төгрөгийг суулгасан. Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/88 дугаар тушаалаар Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдлын удирдлагын багийг баталж, хариу арга хэмжээний үед шилжин, хэрэгжилтийг 92,3% ханган ажилласан. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг засаг даргын 2025 оны А/523 дугаар захирамжаар бшинэчлэн байгуулж, салбар дундын уялдаа холбоог хангаж ажилласан. Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар шуурхай удирдлагын багийг шинэчлэн байгуулж, шуурхай удирдлагын багийн хурлыг 6 удаа хийж, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Улаанбурхан өвчний нийт 68 тохиолдол бүртгэгдэж, хариу арга хэмжээг авч ажилласан. Улаанбурахны тохиолдол 8-10 сард бүртгэгдээгүй байна. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж, онцгой байдлын газар, тагнуулын газар, цагдаагийн газрын удирдлага, мэргэжилтнүүд, сум,	100

			багийн засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагуудын шуурхай удирдлагын багийн гишүүд, хүүхдийн байгууллагын эмч, нийт 145 хүнийг хамруулж, чадавхжуулсан. эмг-ын гамшгийн нөөц 12 нэр төрлийн 4.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, 4.6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27.0 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй, эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 91.0% байна.	
3.2.	Эм био бэлдмэлийн аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтад хяналт тавих;	Жил бүр	<ul style="list-style-type: none"> - Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 72 эмийн сан, 10 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажиллаж байна. - Эмийн хадгалалт, түгээлтэд тавих нийтлэг шаардлага MNS5530:2014 болон эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартын дагуу эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 96,8% байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0,6% нэмэгдсэн байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 97,8%-тай үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,9%-аар сайжирсан байна. -Эм ханган нийлүүлэх байгууллагын стандартын шаардлага 95,8%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,3%-аар сайжирсан байна. /Анхбаяр/ - Улаанбаатар хотоос зориулалтын унаагаар буюу өөрийн компаний унаагаар эм, эмнэлгийн хэрэгсэл татан авдаг 9 Эм ханган нийлүүлэх байгууллага байгаа бол хот хоорондын ачааны унаагаар авч буй 1 байгууллага байгаа нь зориулалтын тээврийн хэрэгслээр авчруулах, стандартын шаардлага хангаж буй унаагаар авчирч байгаа эм ханган нийлүүлэх байгууллагын хувь өмнөх онтой харьцуулахад 24%-аар нэмэгдсэн. - Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас эмийн сан бөөний үнээр эм авч иргэдэд борлуулдаг бөгөөд ЭХНБ-ын үнэ өмнөх онтой харьцуулахад 10-30% нэмэгдсэн бөгөөд эмийн сангууд ЭХНБ-ын үнэ дээр дундажаар 18-30% нэмж борлуулдаг бол бол иргэдэд жижиглэнгийн үнээр борлуулахдаа дундажаар 20-45% нэмж борлуулж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЭХНБ-ын үнэ дээр 5-10% нэмж борлуулж байгаа бол жижиглэнгийн үнээр борлуулж буй үнэ нь 10-25%-аар нэмэгдүүлж борлуулж байна 	100

			- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилдэг 12 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эмийн сангуудаар 1 удаагийн хяналт хийж, хяналтын хэрэгжилт дунджаар 95,5%-тай гарсан бөгөөд өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 1,0%-аар хэрэгжилт сайжирсан. Мөн жилийн эцсийн байдлаар мансууруулах эмийн жорыг 3 байгууллагад 657ш, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 12 байгууллагуудад 4,085ш тус тус шифрлэж олгосон.	
3.6.	Хорт хавдар болон бусад зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлж, оношлох, эмчлэх, осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулахад анхаарч ажиллах;	Жилдээ	<p>2025 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 664,606 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 239,019 хийгдэж 36.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1 хувиар өссөн байна.</p> <p>Ургийн гажгийн эрт илрүүлэг – Аймгийн хэмжээнд пренатологич 2 эмчтэй болж ургийн үзлэг тогтмолжсон. Тайлант хугацаанд 1,357 үзлэг хийснээс өвчний учир 928, идэвхтэй хяналтаар 429 эх бүртгэгдэв. Жирэмсний эрт үеийн нийлмэл илрүүлэгт 141 эхийг хамруулж, эрсдэлтэй 20-оос 13 NIPT, 5 ургийн усны шинжилгээ хийж, эрхтэн тогтолцооны гажигтай 2 жирэмслэлтийг эрт шийдвэрлэв. Ургийн бүтцийн ЭХО-д давхардсан 270 гаруй эмэгтэй хамрагдаж, олон урагтай 18, дээд шатлалд 7 эмэгтэй илгээгдэв. RH-сөрөг жирэмсэн 2, төрөл бүрийн ургийн гажигтай 11 тохиолдол илрүүлж 3-р шатлалд илгээсэн.</p> <p>Нярайн илрүүлэг- тайлант хугацаанд 1610 нярай төрснөөс түнхний ЭХО-д 1605 (99.6%), давтан 1470 хамрагдсан бөгөөд дутуу хөгжил илрээгүй. Сонсголын скринингт 1111, давтан 65 хамруулж 2 нярайг мэргэжлийн эмчид илгээв. Улаан рефлексийн шинжилгээнд 1605 нярай хамрагдаж өөрчлөлтгүй. Бодисын солилцооны скринингт 1180 нярай хамруулж, өөрчлөлттэй 1 нярайг хяналтад авсан. 10-р сараас пульсоксиметрийн скрининг нэвтэрч 165 нярайд зүрхний эмгэг илрээгүй.</p> <p>Сургуульд суурилсан илрүүлэг- 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн.</p> <p>Ажлын байран дах эрт илрүүлэг үзлэг- 122 байгууллагын 4,071 ажилтан лавлагаа шатлалын урьдчилан сэргийлэх багцад хамрагдсан. Аймгийн хэмжээнд өмнө нь 3 лавлагаа шатлалын эмнэлэг байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгийн багцаар үйл ажиллагаа явуулдаг байсан бол 2025 онд 2 эмнэлгээр нэмэгдэж, нийт 5 эмнэлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Хорт хавдрын илрүүлэг – Тайлант хугацаанд нийт 296 шинэ хорт хавдрын</p>	100

			тохиолдол бүртгэгдсэнээс 39.5% нь эрэгтэй байна. Элэгний хавдрын шинэ өвчлөл 60 (25.2%). Эрт илрүүлгээр 108 (45.3%), өвчний учир хандан 130 (54.7%) оношлогдсон. Диспансерийн хяналт 1540. Хими эмчилгээнд 129, бай эмчилгээнд 55 иргэн хамрагдсан. 2025.09.07-нд Хойд бүсийн ХСҮТ-ийн салбар нээгдэж, мэргэжлийн 3 эмч ажиллан 111 иргэнд үзлэг, зөвлөгөө үзүүлж бүсийн тусламжийг сайжруулсан.	
Долоо. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах				
7.1.	Аймгийн хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийн чанарыг дээшлүүлэх	Сар бүр	<p>Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.1 ногдож байгаа нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 2.1 промиллоор буурсан ба аймгийн дундаж 16.5 болон улсын дундаж 16.8-аас бага байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 69.3% нь нярайн эндэгдэл, 23% нь нялхсын эндэгдэл, 7.7% нь 1-5 насны хүүхдийн эндэгдэл байна.</p> <p>“Нялхсын эндэгдлийг бууруулах төлөвлөгөө”-г 3 бүлэг, 13 арга хэмжээг төлөвлөн Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны эхний 10 сарын байдлаар 90.2% байна. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, эмнэлзүйн удирдамж, тушаал зааврын хэрэгжилт, цаг үеийн болон хариу арга хэмжээ, зохицуулалтын талаар сум, өрхийн эмч нарт 6 удаа мэдээлэл, чиглэл, эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд 3 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Орхон аймагт бүртгэгдсэн ьав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлт, эхийн ноцтой хүндрэлийг авч хэлэлцэх магадлан хэлэлцэх хурлыг 3 удаа зохион байгуулж 11 шийдвэр гаргаж, шийдвэрийн хэрэгжилт 85% байна.</p> <p>ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭМГ-аас эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр зохион байгуулсан 18 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 358 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан.</p> <p>Тайлант хугацаанд 1610 нярай төрсөн ба түнхний үений эхо оношилгоонд 1605 (99.6%), давтан үзлэгт 1470 нярай хамрагдснаас түнхний дутуу хөгжилтэй нярай илрээгүй, сонсголын скринингэд 1111, давтан үзлэгт 65 нярайг хамруулж 2 хүүхдийг ЧХХ-н эмчид илгээсэн. Нүдний угийн улаан рефлексийн илрүүлэгт 1605 нярай хамрагдаж өөрчлөлт илрээгүй байна. Бодисын солилцооны скринингэд 1180, давтан шинжилгээнд 38 (3,2%) нярайг хамруулж, өөрчлөлт илэрсэн 1 нярайг хяналтад авсан. 2025 оны 10-р сараас эхлэн нярайн пульсоксиметрийн скринингийг нярайн тасагт</p>	100

			<p>нутагшуулан 165 нярайг хамруулж зүрхний эмгэг илрээгүй байна. Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 23 нярайд хийж, 82.6%-ийн үр дүн өгсөн нь өмнөх оны мөн үеэс 7.6%-иар нэмэгдсэн.</p> <p>Нийгмийн халамж нэн шаардлагатай 535 жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд буюу зорилтот бүлгийн 32.5%-д Жентли Айрон бэлдмэлийг 1-2 сарын хэрэглээг олгож үр дүнг тооцон ажиллаа. Уг бэлдмэлийг цус багадалттай – 181 (33.8%), эх барихын ужиг дурьдатгалтай – 86 (16.1%), эх барихын бус бусад эмгэгтэй – 85 (15.9%), нийгмийн халамж нэн шаардлагатай – 111 (20.7%), хөхүүл эх – 72 (13.5%) тус тус олгосон байна.</p>	
Ес. Хүнсний аюулгүй байдлыг хангах				
9.1.	Хүнсний аюулгүй байдлын хяналтын арга хэмжээг өргөн хүрээнд хэрэгжүүлж, баталгаат байдлыг хангах,	Улирал бүр	<p>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 8 удирдамжийн дагуу хяналт шалгалтад 404 объектыг 100 хувь хамруулж, нийт 433 зөрчлийг илрүүлэн 397 буюу 91,6 хувийг газар дээр нь арилгуулан 36 албан шаардлагаар 11 объектод хугацаатай үүрэг өгч биелэлт 84,8 хувьд байгаа нь өмнөх оныхоос 4,8 хувиар нэмэгдэж зорилтот түвшинд хүрсэн үр дүнтэй байна. Илэрсэн зөрчилтэй холбоотойгоор 9 иргэнд . 2.100,000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч бүрэн барагдуулан, 6 дүгнэлт гаргаж, 261 заалттай хамтарсан 8 актаар хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 21 төрлийн 878 000 төгрөгний 285 ширхэг эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнд акт үйлдэж хураан авч, 223200 төгрөгний хүүхдийн бэлэгт багцлахад хэрэглэх хүчинтэй хугацаа дуусахад 2-10 хоног үлдсэн болон болон бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал алдагдсан барааг газар дээр нь устгуулсан. Наадмын талбай, нийтийн үйлчилгээг явуулах зам талбайн хөрсний халдваргүйтгэлийг 3 давтамжтай хийлгүүлж, хог хаягдлыг цэвэрлүүлж ачуулсан. Хими, хор, нян судлалын 8 төрлийн шинжилгээний 240 дээж авч, шинжлүүлэн, 14 сорилын дүн шаардлага хангаагүй зөрчлийг халдваргүйтгэл, ариутгалыг хийлгэж арилгуулж, Хяналт шалгалтын дүнг Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлж эрсдэлийг бууруулах бодлого чиглэлийн 4 шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн. Дотоод хяналтыг сайжруулах салбарын сургалтад 342 объектыг буюу 77 хувийг хамруулж, шилэн хяналтын цахим системд мэдээллийн санг бүрдүүлсэн. Төлөвлөгөөт, хяналт хамрагдсан нийт 61 объектод 100 хувь зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлүүлснээс хоол үйлдвэрлэлийн 50 байгууллага үүнд нийтийн хоол үйлдвэрлэлийн 5, эмнэлгийн 13, сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн 32 , хүнсний үйлдвэр 5, цэвэр усны 2</p>	100

			<p>үйлдвэр, бялуу, нарийн боовны 4 үйлдвэрт үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн бүртгэлээр тавих 9 хяналт, шинжилгээгээр баталгаажих 8 үзүүлэлтийг шаардлага хангуулж, 73 заалттай 15 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан үр дүнд хүрсэн. 8, 15 дугаар сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрын өртөтгөлийн зураг төслийн хяналт хийж, ашиглалт авах комисст ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хоол үйлдвэрлэлийн ажлын байранд эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөл байдалд улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлснээр ажлын байранд засвар хийх зардлыг шийдвэрлүүлэн зураг төслийн шатанд байна. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн зохион байгуулсан сургалтад эрүүл ахуй халдвар хамгааллын 4 улсын байцаагчид хамрагдаж гэрчилгээ авсан.</p>	
--	--	--	--	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ЭМГСЗТҮХА Б.БАТЦЭЦЭГ
ХЯНАСАН: ЭТЧЭМИХАМ П.ХИШГЭЭ